

Цэцэрлэгийн багшийн ажлын цаг ба оюутан ээлжийн багш ажиллуулах үйл ажиллагаанд хийсэн туршилт судалгааны зарим үр дүн

Доржийн Сарантуяа¹, Гүнсэнгийн Монголхатан¹, Хажидмаагийн Отгонбаатар¹

¹ Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны сектор

Өгүүллийн мэдээлэл	ХУРААНГУЙ
<p>Түүх:</p> <p>Хүлээн авсан: 2022.12.10 Засаж сайжруулсан: 2022.12.24 Хэвлэхийг зөвшөөрсөн: 2022.12.26</p>	<p>Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд цэцэрлэгийн багшийн сургалт, үйл ажиллагаанд бэлдэх, хүүхдийг ажиглах, судалгаа хийх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний ажлын чанарыг сайжруулахаар 2023 оноос эхлэн бүлэг бүрд хоёр ээлжийн бүлгийн багш ажиллуулахаар тусгасан. Энэхүү ажлын хэрэгжилтийг хангах хүрээнд багшийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжих бодит цагийг уртасгахад чиглэн цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулсан туршиж, цаашид ажиллах боломжийг илрүүлэхийг зорилоо. Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах туршилтын үйл ажиллагааны явцад бүлгийн болон ээлжийн багшийн үйл ажиллагааг судлахдаа тоон болон чанарын хосолсон аргаар мэдээлэл цуглуулсан. Туршилтын үр дүнд бүлгийн багш нарын ажлын цагийг багасгаж, ээлжийн багшийн заах арга, хүүхэдтэй ажиллах арга барилд өөрчлөлт гарч, цэцэрлэгийн арга зүйч, багш, сурагчдын хамтын ажиллагаа сайжирсан зэрэг туршилтын үр дүнг энэхүү нийтлэлд толилуулж байна.</p>
<p>Түлхүүр үг:</p> <p>бүлгийн багш ээлжийн багш туршилтын үйл ажиллагаа багшийн ажлын цаг ажлын чиглэл</p>	
<p>Холбоо барих зохиогч:</p> <p>Доржийн Сарантуяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны сектор sarantuya@mnier.mn</p>	

УДИРТГАЛ

Сургуулийн өмнөх боловсролын 1453 байгууллагад, 13199 багш, 7788 туслах багш нар (БШУЯ, 2022) ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030) зэрэг баримт бичигт 1) цэцэрлэгийн багшийн ажлын чанарыг сайжруулах, сургалтын үйл ажиллагаанд бэлдэх, хүүхдийг ажиглах, судалгаа хийх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ; 2) сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана; 3) 2021 оноос эхлэн 30-аас дээш бүлэг дүүргэлттэй ангид, 2023 оноос эхлэн бүлэг бүрд хоёр ээлжийн бүлгийн багш ажиллуулна хэмээн заасан тул Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Түр журам батлах тухай” А/292, А/525 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Коронавируст халдвар (Ковид-19)-ын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-д цэцэрлэгт 5 настай хүүхдийг бүрэн, өмнөх хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдсан 4 настай хүүхдийг үргэлжлүүлэн хүлээн авах, эцэг эх, асран хамгаалагчийн саналд үндэслэн 5 настай хүүхдийг зайн сургалтад хамруулах, цэцэрлэгийн үндсэн бүлэгт хамрагдах боломжгүй 5 настай хүүхдийг хувилбарт сургалтад хамруулахаар заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Цэцэрлэгт ээлжийн

Санал болгож буй эшлэл:

Сарантуяа, Д., Монголхатан, Г., Отгонбаатар, Х. (2022). Цэцэрлэгийн багшийн ажлын цаг ба оюутан ээлжийн багш ажиллуулах үйл ажиллагаанд хийсэн туршилт судалгааны зарим үр дүн. *Боловсролын судалгааны монголын сэтгүүл*, 27(1). 29-43. DOI: <https://doi.org/10.56380.v27.3>

багш ажиллуулах тухай” А/214 дүгээр тушаалаар нийслэлийн сонгогдсон 25 цэцэрлэгийн 60 бэлтгэл бүлэгт “Оюутан-ээлжийн багш” (цаашид ээлжийн багш гэх)-ийг 2021-2022 хичээлийн жилд 9 сарын хугацаанд ажиллуулахаар шийдвэрлэсэн. Багшийн ажил нь ердийн нөхцөлд тооцогддог ба ажлын цаг нь Хөдөлмөрийн хуулинд зааснаар “Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй (84.1), ердийн ажлын өдрийн үргэлжлэл найман цагаас илүүгүй (84.2.) (legalinfo.mn, 2021)” байдаг. Цэцэрлэгийн багшийн ажлын ачааллыг бууруулах, багш болох оюутныг дадлагажуулах зорилгоор цэцэрлэгт ээлжийн багш ажиллах боломжийг 2021 оны хичээлийн жилд нийслэлийн 25 цэцэрлэгийн 60 бэлтгэл бүлэгт БШУЯ-наас гаргасан Түр журам, СӨБС-ийн захирлын тушаал, шийдвэрийн хүрээнд төгсөх ангийн оюутнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлэн түршилтын ажлыг зохион байгуулав.

Сэдвийн судлагдсан байдал

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ажлын ачаалал, үнэлгээ судалгааны хүрээнд цэцэрлэгийн багш нар нийт 38 ажил гүйцэтгэдэг бөгөөд эдгээр ажлын 2 нь байгууллагын дотоод журмын дагуу, 10 нь ажил гүйцэтгэлийн хүрээнд үнэлэгддэг бол 26 нь тодорхой хэмжээнд үнэлэгддэггүй (БСШУЯ, Боловсролын хүрээлэн, 2006) гэсэн үр дүн гарчээ. Мөн энэхүү судалгааны цэцэрлэгийн багш нараас авсан асуулгын судалгаагаар дэвшүүлсэн саналын хүрээнд багшийн ажлын ачаалал, үнэлгээний асуудлыг шийдвэрлэх нэг зүйл нь ээлжийн багштай болох гэж хариулсан нь анхаарал татаж байна. Харин Боловсролын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд дурдсан судалгааны үр дүнгээс харвал, нийслэл болон аймгийн төвийн цэцэрлэгийн багш нар өдөрт 10-12 цаг буюу 7 хоногт 50 гаруй цаг ажиллаж, хүүхдийн өдрийн унтлагын цагт сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хөтөлбөр боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн болон дараагийн хичээлийн бэлтгэл зэргийг хийдэг ч ажлын бус цагаар дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багагүй цаг зарцуулж байна (Дэлхийн банк, БТДНТ, 2019) гэсэн үр дүнг гарчээ. Бид багшийн ажлын ачааллыг бууруулах боломжийг илрүүлэхийн тулд ээлжийн багшийн түршилтын үйл ажиллагааны хүрээнд бүлгийн багшийн ажлын байрны зураглалыг тандан судаллаа. Өмнө нь цэцэрлэгт ээлжийн багш ажилласан түршлага, судалсан судалгаа одоогоор байхгүй байна.

Судалгааны арга зүй

Судалгааны зорилго нь цэцэрлэгт ээлжийн багш ажиллах түршилтын явцад бүлгийн болон ээлжийн багшийн ажлын байрны зураглалыг тандан судалж, цаашид хэрэгжүүлэх боломжийг илрүүлэхэд оршино.

Судалгаагаар тодруулах дараах зүйлийг тодруулна:

1. Ээлжийн багш ажилласнаар бүлгийн багшийн ажлын ачаалалд гарах өөрчлөлт
2. Ээлжийн багш ажиллахад тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх боломж
3. Бүлгийн болон ээлжийн багшийн ажлын байрны зураглал


Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах үйл ажиллагааг түршилт хийхээр саналаа ирүүлсэн нийслэлийн 6 дүүргийн 25 цэцэрлэгийн 60 бүлэгт МУБИС-ийн СӨБС-ийн төгсөх ангийн болон 3-р дамжааны оюутнууд ажиллаж хэрэгжүүлсэн.

Судалгааны арга, аргачлал

Түршилтын явцад гарч буй өөрчлөлтийг илрүүлэхдээ тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй цэцэрлэг болон хяналтын цэцэрлэгийг сонгон авч мэдээлэл цуглуулж, харьцуулан шинжилгээ хийв. Бүлгийн болон ээлжийн багшийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж буй байдлыг ажлын таван өдөрт тасралтгүйгээр ажиглан тэмдэглэл хөтөлж хийсэн ажилд зарцуулж буй хугацааг гарган багшийн албан тушаалын дагуу гүйцэтгэх ажилд бүлэглэн кодлож боловсруулалт хийсэн. Түршилтын хугацаанд бүлгийн болон ээлжийн багшийн хамтын ажиллагаанд гарч буй эерэг, бэрхшээлтэй асуудлыг илрүүлэн түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, үндэсний хэмжээнд ээлжийн багш ажиллах боломж, нөхцөлийн талаар удирдамжийн дагуу чиглүүлэх асуултын хүрээнд ярилцаж хариултыг бүлэглэн давтамжаар нэгтгэж чанарын боловсруулалт хийв. Түршилтын

хугацаанд бүлгийн болон ээлжийн багшийн хамтын ажиллагаанд гарч буй эерэг, бэрхшээлтэй асуудлыг илрүүлэн түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, үндэсний хэмжээнд ээлжийн багш ажиллах боломж, нөхцөлийн талаар удирдамжийн дагуу чиглүүлэх асуултын хүрээнд ярилцаж хариултыг бүлэглэн давтамжаар нэгтгэж чанарын боловсруулалт хийв. Мөн түршилтыг зохион байгуулсан цэцэрлэгийн 11, 1, 3 сард тасралтгүй явсан хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчаас энэхүү үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгааг асуулгын аргаар авч боловсруулж үр дүнг тооцов. Цуглуулсан тоон мэдээлэлд SPSS програмд статистик боловсруулалт хийв.

Судалгааны зохион байгуулалт, дизайн




Түршилтад нийслэлийн Баянгол дүүргийн 3, Баянзүрх дүүргийн 7, Сонгинохайрхан дүүргийн 4, Сүхбаатар дүүргийн 5, Хан Уул дүүргийн 2, Чингэлтэй дүүргийн 4 цэцэрлэг хамрагдсан. Эдгээр 25 цэцэрлэгээс пропорцианаль аргаар эхний түүврийг, санамсаргүй түүврийн аргаар 2 дахь шатны түүврийг хийж 12 цэцэрлэгийг сонгон авч эдгээрийн ойролцоо байршилд баримжаалан хяналтын 12 цэцэрлэгийг сонгон авч ажиглалт хийв. 36 сургалт, үйл ажиллагаанд сууж ажиглалтын хуудсанд хийж буй үйлийг зарцуулж буй хугацаагаар тэмдэглэн мэдээлэл цуглуулав. Ажиглалтын судалгаанд хамрагдсан түршилтын 12 цэцэрлэгийн 4 эрхлэгч, 6 арга зүйч, 10 бүлгийн, 9 ээлжийн багш нартай судалгааны удирдамжийн дагуу бүлгийн ярилцлага хийв. Асуулгын судалгаанд түршилтын 25 цэцэрлэгийн 23 эрхлэгч, 20 арга зүйч, 53 бүлгийн багш, 57 ээлжийн багш, 57 эцэг эх, асран хамгаалагч хамрагдлаа.

ҮР ДҮН

Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулж буй үйл ажиллагааг судлахдаа ажиглалт, ярилцлага, асуулгын аргаар мэдээллийг цуглуулж шинжилгээ хийв.


Судалгааны хүрээнд асуулга, ярилцлага, ажиглалтын аргаар нийслэлийн түршилтын 25, хяналтын 12 цэцэрлэгээс түүврийн дагуу мэдээлэл цуглуулаа.

Ажиглалтын судалгаанд нийт 24 цэцэрлэгийн 24 бүлгийн багш, 12 ээлжийн багш хамрагдав. Ажиглалтын судалгаанд 100 хувь эмэгтэй, асуулгын судалгаанд 0.7 хувь эрэгтэй, 99.3 хувь нь эмэгтэй, ярилцлагын судалгаанд 100 хувь эмэгтэй байв.



Зураг 1. Судалгаанд хамрагдсан багш нар (насаар)

Судалгаанд хамрагдсан багш нарын дийлэх 40 орчим хувь нь 25 хүртэлх насны, 15 орчим хувь нь 36-40 насных ба нас бүрээс төлөөлөл байв. Харин эцэг эхчүүдийн 30 гаруй хувь нь 31-35 насныхан байв.




Зураг 2. Судалгаанд хамрагдсан багш нар (ажилласан жилээр)

Судалгаанд хамрагдсан багш нарын 40 орчим хувь нь 2-10 жил ажилласан багш нар байсан бөгөөд 37.3 хувь нь ээлжийн багш, 34.6 хувь нь бүлгийн багш, 15.0 хувь нь эрхлэгч, 13.1 хувь нь арга зүйч байв.

Ээлжийн багшийн үйл ажиллагааны үр дүнд гарч буй өөрчлөлт


Ээлжийн багшийн үйл ажиллагааны өөрчлөлтийг бид бүлгийн багшийн цагийн зохицуулалт, ээлжийн багшид гарч буй өөрчлөлт, байгууллагын буюу цэцэрлэгийн хувьд ямар өөрчлөлт гарч байгааг илрүүлэхийн зэрэгцээ эцэг эх, асран хамгаалагчийн ажлын цагтай хэрхэн уялдаатай байгааг илрүүлж, үр дүнг тооцохыг зорилго.

Цэцэрлэгийн багшийн ажлын цагт гарч буй өөрчлөлт: Бидний судалгааны зорилго нь багшийн ажлын цаг буурч байгааг илрүүлэх бөгөөд асуулгын судалгаанд туршилтын үйл ажиллагааг зохион байгуулсан 25 цэцэрлэгийн 23 эрхлэгч, 20 арга зүйч, 53 бүлгийн багш, 57 ээлжийн багш, 57 эцэг эх, асран хамгаалагч асуулгын судалгаанд хамрагдсан байв.



Зураг 3. Ажиллаж буй цаг (асуулгын судалгаа бүх оролцогчдоор)

Асуулгын судалгаанд оролцогч бүлгийн багш нарын 49.2 хувь нь 8-9 цаг, 43.3 хувь нь 10 цаг, 64.9 хувь нь 5 цаг, 17.5 хувь нь 4 цаг ажиллаж байв.



Зураг 4. Судалгаанд хамрагдсан багш нарын ажлын цаг

Ажиглалтын судалгаанд хамрагдсан багш нарын 50 гаруй хувь нь 10-11 цаг ажилласан ба хяналтын цэцэрлэгийн бүлгийн багш нарынх 8.3 хувиар илүү байв. Туршилтын болон хяналтын цэцэрлэгийн бүлгийн багш нарын өдөрт ажиллах дундаж хугацаа 10.2 цаг буюу ижил байв. Хэдий ийм үр дүн харагдаж байгаа боловч ажиглалтын судалгаанд хамрагдсан багш нарын хийж буй үйлийг, зарцуулж буй цагаар нь ялган авч үзэхэд туршилтын цэцэрлэгийн багш нар сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт хийх, сургалтын хэрэглэгдэхүүн хийх, ээлжийн багшийн үйл ажиллагаанд зөвлөх ажлыг хийж байсан бөгөөд 12 багшийн 6 нь буюу 50 хувь нь дунджаар 11.3-37.7 хүртэлх хувийг сургалттай холбоогүй бусад үйл буюу эмнэлэг явах, дасгал хөдөлгөөнд оролцох, архивын ажил хийх, нөгөө анги, няравын өрөөнд байх гэх мэт ойр зуур орж гарах үйлд зарцуулсан байв. Харин хяналтын цэцэрлэгийн 12 багшийн 4 нь буюу 33.5 хувь нь сургалттай холбоогүй үйлд 10.2-22.0 хувийг зарцуулахдаа тэмцээнд ээлтгэх, бариулахаар явах, тариа хийлгэх, эмнэлэг явах, кофе цай уух, ойр зуур гарч орох үйлийг хийснийг судалгаа харууллаа. Харин ээлжийн багш нар өдөр 14.00-15.00 цагийн хооронд ирж ойролцоогоор 4-5 цаг ажиллаж 19.30-20.00 цагт таржээ.

Туршилтын үйл ажиллагаанаас багшийн цагийн өөрчлөлтөд дараах үр дүн гарлаа:

- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлтийг бүлгийн багшийн илүү цагийн хөлс, ээлжийн багшийн цалин хөлснөөс гадна тэдний мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа, хүүхдийн хөгжил, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, орчин бүрдүүлэхэд эерэгээр нөлөөлж байгаа нь туршилтын үйл ажиллагааны үр дүнг харуулж байна.
- Бүлгийн багш нар хэвийн нөхцөлд өдөрт дунджаар 10-11 цаг ажиллаж байсан бол туршилтын үйл ажиллагааны явцад 50 орчим хувь нь 8-9 цаг болж буурсныг судалгаа харуулж байна.
- Ажиглалтын судалгаанд хамрагдсан бүлгийн багш нар ээлжийн багшийг байх хугацаанд сургалт, үйл ажиллагаанд бэлтгэх, хэрэглэгдэхүүн хийхэд цагаа зарцуулж байгаа нь сургалт, үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдсэн гэж үзэж болно.

Цэцэрлэгт ээлжийн багш ажилласнаар гарч буй давуу талуудын оюутан мэргэжилдээ дадлагажих боломж бүрдсэн гэж 81.7 хувь, оюутан орлоготой болсон гэж 79.7 хувь, ээлжийн багшаар оюутан ажиллуулсан 61.4, эцэг эх асран хамгаалагчийн ажлаа хийх боломжийг олгосон гэж 60.1 хариулжээ. Бүлгийн багш өөрийн гэр бүл, эрүүл мэнддээ анхаарах боломж бүрдсэн гэж 49 хувь нь гэж судалгаанд оролцогчид хариулжээ. Эдгээр нь ээлжийн багш ажиллуулах явцад авч хэрэгжүүлсэн ажлууд бөгөөд энэхүү туршилтын үйл ажиллагааны эерэг үзүүлэлт болж байна.

Ярилцлагын үр дүнгээс гол санааг дор дурдъя:

- Ээлжийн багш ажиллах явцдаа сайн чадвартай багш болох туршлагатай болж байна.
- Ээлжийн багшийн хувьд суралцангаа нэмэлт орлоготой болсон.
- Ээлжийн багшаар мэргэжлийн багш ажиллавал бүлгийн багшийн хувьд өөрийгөө хөгжүүлэх гэр бүлтэй цаг зав гаргах, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах
- Оюутан багшаас суралцах, цэцэрлэгийн уур амьсгалд эерэгээр нөлөөлж байна. Мөн харилцан бие биенээсээ суралцан хамтран ажиллах туршлагатай болсон.
- Бүтээлч сэтгэлгээг бусдадаа түгээх боломж бүрдсэн.
- Урлаг спортын авьяастай оюутнууд манлайлан оролцож байсан.
- Хүүхдээ сургуульд өгч байгаа залуу багшид боломж олгосон.
- Тэтгэвэрт гарах дөхсөн багшид илүү цагийн мөнгөтэй холбоотой хүндрэл үүссэн. Нэг багшид хуваарилах биш бүх багш нарт адилхан ээлжийн багш ажиллуулах зүгээр санагдсан.

Туршилтын үйл ажиллагаанаас цэцэрлэгт гарч буй өөрчлөлт, үр дүнг үзүүлье:

- Туршилтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны явцад хамтын ажиллагаа хөгжсөнийг судалгаа харууллаа.
- Туршилтын хугацаанд зохион байгуулсан арга зүйн сургалт, арга зүйчийн үр чадварт, ээлжийн багшийн хичээл зохицуулалт дэмжлэг болж байгаа гэж 50 гаруй хувьтай хариулсан нь туршилтын үйл ажиллагааны үр дүнтэй байсныг харуулж байв.


Ээлжийн багшид тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх боломж: Ээлжийн багш ажилласнаар тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж шийдвэрлэх боломжийг илрүүлснээр цаашид ээлжийн багш ажиллах боломжийг харж болно. Мөн тулгарч буй бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэж болох талаар тодруулан судаллаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ээлжийн багшийн үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл (давтамжаар)

№	Тулгарч буй бэрхшээл	Байнга	Заримдаа	Хааяа	Бараг үгүй	Үгүй
1	Хүүхэдтэй харилцах	37.9	20.3	13.1	11.1	17.6
2	Хүүхэд тараах	35.3	14.3	12.4	10.5	27.5
3	Ажил хүлээлцэх (хүүхэд хүлээлцэж гарын үсэг зурах)	34.6	17.1	13.7	7.8	26.8
4	Хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	34	19	19.6	9.8	17.6
5	Хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт хийх	33.3	21.6	17.6	9.9	17.6
6	Сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт хийх	32.7	24.8	18.3	7.8	16.3
7	Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх	30.7	23.5	18.3	11.2	16.4

8	Сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах	29.4	24.2	20.9	7.9	17.6
9	Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах	28.1	24.8	19.6	11.2	16.3
10	Цахимаар хичээл орох	12.4	18.3	23.5	13.7	32.1
11	Цалин хөлстэй холбоотой асуудал үүсэх	24.8	20.9	23.5	5.3	25.5
12	Ковидын ойрын хавьтал болох	11.8	17.6	22.2	11.8	36.6
13	Багш нарын хандлага сөрөг байх	9.8	28.1	20.3	9.8	32
14	Цэцэрлэгт хоол идэхгүй ажиллах	14.4	23.5	22.2	9.2	30.7
15	Хийх ажил тодорхойгүй байх	7.2	19	21.6	11.8	40.4
16	Ээлжийн багштай ойлголцохгүй байх	8.5	20.9	22.2	9.2	39.2

Судалгаанд хамрагдагсдын ихэнх хувь буюу 30 гаруй хувь нь хүүхэдтэй харилцах, хүүхэд тараах, ажил хүлээлцэх, хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөх, сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт хийхэд бэрхшээл учирдаг гэж хариулжээ. Тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд зарим талаар хүндрэлтэй гэж 63.4 хувь нь, хүндрэлгүй гэж 43.0 хувь нь хариулжээ.



Зураг 5. Бэрхшээлийг хэнтэй хамтран шийдвэрлэж байгаа талаар (асуулгын судалгаанд оролцогчдоор)

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 51.0 хувь нь тулгарч буй бэрхшээлийг арга зүйчтэй хамтран шийдвэрлэдэг гэж хариулжээ.


Туршилтын үйл ажиллагааны явцад ээлжийн багшид тулгарч буй бэрхшээл, шийдэх боломж, үр дүн:

- Цэцэрлэгт ээлжийн багш ажиллахад тулгарч буй бэрхшээл нь харьцангуй зохион байгуулалтын шинжтэй, тухайлбал, хүүхэд хүлээлцэх, тараах гэсэн бол сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хүүхэдтэй харилцах гэсэн бэрхшээлийг шийдвэрлэх боломжтой гэж хариулсан бөгөөд үүнийг цэцэрлэгийн арга зүйчтэй хамтран шийдвэрлэсэн гэж хариулсан байв.

Туршилтын явцад эцэг эх, асран хамгаалагчид үзүүлж буй дэмжлэг, үр дүн:

- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ эрт өгч, орой эрт авч байгаа ба энэ хугацаанд хүүхдийн бие бялдрын хувьд ядрах байдал ажиглагдаагүй гэж 90 гаруй хувь нь хариулжээ.
- Цэцэрлэгт цагийн зохицуулалт хийж ээлжийн багш ажиллуулснаар эцэг эх, асран хамгаалагчид ажлаа хийх, нэг ангид 3 багш ажиллах боломжийг бүрдүүлсэн.
- Цагийн зохицуулалт хийснээр авто замын түгжрэлтэй холбоотой дүгнэлт гаргах боломжгүй байсан нь тухайн эцэг эхчүүдийн хүүхдээ өгч буй цэцэрлэг ойрхон байгаатай холбоотой байж болох юм.

Нийт судалгаанд оролцогчдоос ээлжийн багшийн хэрэгцээ байгаа болон ажиллуулах боломжтой эсэхийг тодруулахад дараах үр дүн гарлаа.



Зураг 3. Ээлжийн багшийн хэрэгцээ, ажиллуулах боломжийн талаар

Судалгаанд оролцогчдын 62.7 хувь нь ээлжийн багш хэрэгтэй, 58.2 хувь нь ажиллуулах боломжтой гэж хариулжээ.

Цэцэрлэгийн багшийн ажлын байрны зураглал: Ээлжийн багшийн үйл ажиллагааны ажиглалтын судалгааг БСҮХ-ийн 16 судлаач бүлгийн болон ээлжийн багш нарын 5 хоногийн сургалт, үйл ажиллагааг тасралтгүйгээр ажиглаж хийж буй үйл, зарцуулж буй цагаар ажиглалтын хуудсанд тэмдэглэж мэдээлэл цуглуулав.


Ажиглалтын аргаар туршилтын болон хяналтын цэцэрлэгийн багшийн хийж буй үйл ажиллагааг түүнд зарцуулж буй хугацааг тэмдэглэн бүлгийн багшийн ажлын байрны зураглалыг тандан судлахыг зорилоо.

Багш нарын хийж буй үйлийг хугацаагаар тэмдэглэн авч дүн шинжилгээ хийхдээ тэдний албан тушаалын тодорхойлолтод заасан а) сургуулийн өмнөх сургалтын үндэсний хөтөлбөр, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг багшийн бие даасан хөтөлбөрөөр дамжуулан шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай, тогтвортой хэрэгжүүлж, хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, б) хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хоол, хүнсний ариун цэврийг сургалтын орчинд хариуцаж, халдварт өвчин, гэмт халдлага, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, асран хамгаалах үйл ажиллагааг эцэг, эх, асран хамгаалагчийн байнгын оролцоо дэмжлэгтэйгээр гүйцэтгэх, в) хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэцийн хөгжлийн явц, үр дүнг суралцахуйн чиглэл бүрээр ажиглаж судлан, онцлог хэрэгцээнд нь нийцсэн сургалтын орчин бүрдүүлж, сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, үнэлэх, г) хүүхдийн хүмүүжил, төлөвшил, нийгэмшихүйн хөгжлийг цэцэрлэг, гэр бүл, нийгмийн бусад орчинд адил тэгш хангахуйц сургалт, үйл ажиллагааг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, энэ чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх гэсэн 4 зорилтын хүрээнд сургалт, үйл ажиллагааг зохион байгуулдаг ажлууд руу кодлон зарцуулж буй хугацааг 0-5, 6-10, 11-15, 16-20, 21-25, 26-30, 31-ээс дээш гэсэн интервалаар боловсруулалт хийв.

Хүснэгт 2. Ажиглалтын судалгааны түүвэр (тоогоор)


№	Дүүрэг	Туршилтын цэцэрлэгийн тоо	Туршилтын		Хяналтын
			Бүлгийн багшийн түүврийн тоо	Ээлжийн багшийн түүврийн тоо	Бүлгийн багшийн түүврийн тоо
1	Баянгол	3	1	1	1
2	Баянзүрх	7	4	4	4
3	Сонгинохайрхан	4	2	2	2

4	Сүхбаатар	5	2	2	2
5	Хан Уул	2	1	1	1
6	Чингэлтэй	4	2	2	2



Зураг 4. Судалгаанд хамрагдсан бүлгийн хүүхдийн ирц (хувиар)

Ажиглалтын судалгааны 5 хоногт ангийн хүүхдийн ирцийн 50 гаруй хувь нь 21-30, 40 гаруй хувь нь 11-20 хүүхэд байсан бөгөөд 5 дахь өдөр харьцангуй цөөрч дийлэнх хувь нь 11-20 хүүхэдтэй байх нь нийтлэг байв.



Зураг 5. Ажлаас тардаг цаг (бүх оролцогчдоор)

Асуулгын судалгаанд хамрагдсан бүлгийн багш нарын 83.0 хувь нь 18.00-18.30, ээлжийн багш нарын 77.2 хувь нь 18.30-19.30, 5.3 хувь нь 19.30-20.00 цагт ажлаасаа тардаг гэж хариулжээ.

Хүснэгт 3. Ажиглалтын үр дүн


Албан тушаалын зорилт	Албан тушаалын чиг үүрэг	Ажиглалтын үр дүн	
		Түршилтын	Хяналтын
	1. Сургалтын үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, багшийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг судлах, үйл	Ажиглагдаагүй.	Ажиглагдаагүй

Сургуулийн өмнөх сургалтын үндэсний хөтөлбөр, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг багшийн бие даасан хөтөлбөрөөр дамжуулан шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай, тогтвортой хэрэгжүүлж, хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх	ажиллагаандаа тогтмол баримтлах;		
	2. Цэцэрлэгийн үзэл баримтлал, хөгжүүлэх хөтөлбөр, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, байгууллагын эрх зүйн орчин бүрдүүлэхэд идэвхтэй оролцох, тэдгээрийг эцэг, эх, асран хамгаалагч, иргэдэд сурталчлах;	Ажиглагдаагүй.	Ажиглагдаагүй
	3. Мэргэжлийн онол, арга зүйн ур чадвараа байнга дээшлүүлж, заах аргын нэгдлийн ажилд оролцон дэмжлэг үзүүлж, ажлын амжилт туршлагаа түгээн дэлгэрүүлэх, бусад багшаас суралцах;	Судалгаанд хамрагдсан 12 багшийн 1 нь 480 минутаар буюу бүтэн өдрөөр, 7 нь 30-260 минутын буюу өдөртөө богино хугацаагаар сургалтад ажлын 5 хоногт 1-2 давтамжтайгаар суусан байв.	Судалгаанд хамрагдсан 12 багшийн 2 нь 480 минутаар буюу бүтэн өдрийн, 4 нь 20-120 минутын богино хугацааны сургалтад ажлын 5 хоногт 1-2 давтамжтайгаар суусан байв.
Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хоол, хүнсний ариун цэврийг сургалтын орчинд хариуцаж, халдварт өвчин, гэмт халдлага, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, асран хамгаалах үйл ажиллагааг эцэг, эх, асран хамгаалагчийн байнгын оролцоо дэмжлэгтэйгээр гүйцэтгэх.	1. Бага насны хүүхдийн эрүүл мэнд, аюул осолгүй байдлыг тогтмол хангаж, халдварт өвчин, гэмт халдлага, байгалийн гамшигт үзэгдэл зэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд анхаарч, холбогдох ажилтан, эмч, тогооч нарт дэмжлэг үзүүлж ажиллах, шаардлага тавих;	Туршилтын болон хяналтын цэцэрлэгийн бүлгийн багш нар хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, өөртөө үйлчлэх дадал хэвшилтэй холбоотой үйлүүд хүүхдийн тооноос хамаарч үргэлжлэх хугацааны хувьд ялгаатай ч ойролцоогоор 10-15 минутад тогтмол өдөр бүр 5-8 удаагийн давтамжтайгаар гүйцэтгэж байв.	
	2. Хүүхдийг эрүүлжүүлж, чийрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааг чанартай зохион байгуулах;	Туршилтын болон хяналтын цэцэрлэгийн бүлгийн багш нар дасгал хөдөлгөөн, нойрсолт, хооллолт, өөртөө үйлчлэх дадал буюу хоолой зайлах, гар угаах, бие засах гэх мэт үйлийг өдөр бүр тогтмол давтамжтайгаар хүүхдүүдийг чиглүүлэх, зохион байгуулах ажлыг гүйцэтгэж байв.	
	3. Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх чадварыг эцэг, эх, асран хамгаалагчдад эзэмшүүлэх;	Ажиглагдаагүй	Ажиглагдаагүй
Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэцийн хөгжлийн явц, үр дүнг суралцахуйн чиглэл бүрээр ажиглаж судлан, онцлог хэрэгцээнд нь нийцсэн сургалтын орчин бүрдүүлж, сургалтын	1. Зохион байгуулсан үндсэн сургалт, бусад үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, тайлагналаа чанартай хийж гүйцэтгэн тэдгээрийн үр дүнд хүүхдийн хөгжилд ахиц, өөрчлөлт гарч байгаа эсэхийг судлан тогтоох, дүгнэх, үнэлэх, үнэлүүлэх;	Сургалт, үйл ажиллагааг сургалтын төлөвлөлтөө хийж түүний дагуу сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах хүүхдүүдтэй ярилцах зэрэг үйлийг өдөр бүр тогтмол 3-аас дээш давтамжтайгаар хийж байв. Давтамжийн тоо нь тухайн багшаас хамаарч ялгаатай байв.	Сургалт, үйл ажиллагааг сургалтын төлөвлөлтөө хийж түүний дагуу сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах хүүхдүүдтэй ярилцах зэрэг үйлийг өдөр бүр тогтмол 3-аас дээш давтамжтайгаар хийж байв. Давтамжийн тоо нь

хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, үнэлэх.		Хүүхдийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг дүгнэх, үнэлэх, үнэлүүлэх, сургалт, үйл ажиллагааг тайлагнах үйл ажиглагдаагүй.	тухайн багшаас хамаарч ялгаатай байв. Хүүхдийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг дүгнэх, үнэлэх, үнэлүүлэх, сургалт, үйл ажиллагааг тайлагнах үйл ажиглагдаагүй.
	2. Хүүхдэд ээлтэй, хүүхдийн хөгжлийг дэмжсэн, сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцсэн, орчны стандартыг хангахуйц сургалтын орчин бүрдүүлэх, боловсронгуй болгох, үүнд эцэг, эх, асран хамгаалагчдын дэмжлэг, оролцоог бий болгож ажиллах;	Сургалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр илүү орчны стандарт руу чиглэсэн үйл ажиллагаа зонхилж байв. Өөр орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл болон эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо ажиглагдаагүй.	Сургалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр илүү орчны стандарт руу чиглэсэн үйл ажиллагаа зонхилж байв. Өөр орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиглагдаагүй. 1 багш эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой ангид 40 минут орчим хугацаанд хуулга нааж сургалтын орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйлийг 1 удаа хийв.
	3. Нарийвчилсан бүтэцтэй болон чөлөөт ажиглалт, хувийн хавтас зэрэг хүүхдийн суралцахуйн хөгжлийг үнэлэх ажлыг хийж гүйцэтгэн үр дүнг Заах аргын нэгдэл, эцэг, эхчүүдэд тайлагнах;	Хүүхдийн хөгжлийн үнэлгээний чиглэлээр 5 хоногийн 1-2 өдөрт 4 багш бүтээлийн хавтас, бүтээлд нэр бичих, 5 багш ажиглалтын тэмдэглэл бичих, 1 багш үнэлгээ өгөх үйлийг гүйцэтгэсэн бол 2 багшид энэ чиглэлийн үйл ажиглагдаагүй.	Хүүхдийн хөгжлийн үнэлгээний чиглэлээр 5 хоногийн 1-2 (1 багш 4 өдөрт) өдөрт 7 багш бүтээлийн хавтас, бүтээлд нэр бичих, 3 багш ажиглалтын тэмдэглэл бичих, 1 багш үнэлгээ өгөх үйлийг хийсэн бол 1 багшид энэ чиглэлийн үйл ажиглагдаагүй.
	4. Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, авьяас чадварыг нээж, хөгжүүлэхэд нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хэрэглэх;	Туршилтын болон хяналтын цэцэрлэгийн бүлгийн багш нар хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, авьяас чадварыг нээх чиглэлээр хийсэн үйл ажиглагдаагүй, сургалт, үйл ажиллагааны төлөвлөлттэй уялдуулан сургалтын хэрэглэгдэхүүн хийх ажлыг өдөр бүр 2-4 удаагийн давтамжтайгаар хийж буй зүйлээс хамаарч 20-120 минут гүйцэтгэж байв.	
	5. Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хөтөлбөрийнхөө үр дүнг үнэлж, боловсронгуй болгох ажлыг багш, Заах аргын нэгдэлтэй хамтран гүйцэтгэж, цэцэрлэгийн удирдлага, эцэг, эх асран хамгаалагчдад олон хэлбэрээр тайлагнах;	Бүлгийн багш нар ажлын 5 хоногийн 3-5 өдөрт 1 удаагийн давтамжтай, 11 багш арга зүйчтэй, 8 багш ээлжийн болон бусадтай, 1 багш эрхлэгчтэй, 2 багш байгууллагын хуралд оролцож бусадтай хамтран ажиллаж байв.	Бүлгийн багш нар ажлын 5 хоногийн 2-5 өдөрт 1 удаагийн давтамжтай, 10 багш арга зүйчтэй, 2 багш дадлагын багштай, 4 туслах багштай, 2 багш эмч, эрхлэгчтэй уулзаж, 4 багш байгууллагын хуралд оролцож бусадтай хамтран ажиллаж байв.
	6. Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг	Бүлгийн 2 багш ажлын 5 хоногт өдөр бүр сургалт, үйл ажиллагааны явцад	Бүлгийн 2 багш ажлын 5 хоногт өдөр бүр сургалт, үйл

	эзэмшиж, бүлэгтээ байгаа хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх ажлыг гүйцэтгэж, хүүхдийн хөгжлийн өөрчлөлт, ахицыг үнэлж дүгнэх;	ХБХ-ийн үйлийг чиглүүлэх, бусадтай хамтрах байдлаар 2-4 удаагийн давтамжтайгаар ажиллаж байв.	ажиллагааны явцад ХБХ-ийн үйлийг чиглүүлэх, бусадтай хамтрах байдлаар 1-2 удаагийн давтамжтайгаар ажиллаж байв.
Хүүхдийн хүмүүжил, төлөвшил, нийгэмшихүйн хөгжлийг цэцэрлэг, гэр бүл, нийгмийн бусад орчинд адил тэгш хангахуйц сургалт, үйл ажиллагааг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, энэ чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх	1. Хүүхдийг хөгжүүлэх, хүмүүжүүлэх сургалт, үйл ажиллагааны агуулга, хэлбэрт үндэсний хэл, соёл, ёс заншил, орчин үеийн нийгмийн харилцаа, гэр бүлийн үнэт зүйлсийг тусган хэрэгжүүлэх;	Ажиглагдаагүй.	Ажиглагдаагүй.
	2. Гэр бүлийн орчинд хүүхдийг хөгжүүлэх, зохистой хүмүүжүүлэх арга зүй, үр чадварыг эцэг, эх, асран хамгаалагчдад эзэмшүүлж, байнга хамтран ажиллах;	Бүлгийн багш нарын эцэг эх, асран хамгаалагчид чиглэсэн ажил ажлын 5 хоногт өдөрт 1-2 удаагийн давтамжтайгаар 4 багш утсаар, 3 багш хүлээж авах, өгөх хугацаанд ярилцах байдлаар ажиллаж, 5 багш ажиглагдаагүй.	Бүлгийн багш нарын эцэг эх, асран хамгаалагчид чиглэсэн ажил ажлын 5 хоногт өдөрт 1-2 удаагийн давтамжтайгаар 5 багш утсаар ярих, 3 багш хүлээн авах, өгөхдөө ярилцах, 1 багш тэмцээний талаар бэлтгэх, ярилцах, 1 багш хурал хийж, 1 багш ангиа тохижуулахад хамтарсан бол 1 багш ажиглагдаагүй.
	3. Багшийн ёс зүйн дүрэмд заасан ёс суртахууны хэм хэмжээг үйл ажиллагааныхаа чиглэл бүрд сахин биелүүлж ажиллах;	Онцгой ёс зүйгүй үйл ажиглагдаагүй.	Онцгой ёс зүйгүй үйл ажиглагдаагүй.

Дээрх ажиглалтын тэмдэглэлээс үзвэл багш бүрийн өдөрт хийж буй ажлын агуулга ижил боловч хугацаа, давтамжийн хувьд ялгаатай дүр төрх харагдаж байна.



Зураг 6. Цэцэрлэгийн багш албан тушаалын хүрээнд гүйцэтгэж буй үйлд өдөрт зарцуулах хугацаа (хувиар)

Сургуулийн өмнөх боловсролын багш нар албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн 2,3-р зорилтын хүрээнд хийх зарим ажлыг, тухайлбал, 2-р бүлэг ажлын хүүхдийн эрүүл, мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, 3-р бүлэг ажлын хүрээнд сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүн хийх, хүүхдийн хөгжлийг дэмжих, үнэлэх ажлыг тодорхой хугацаанд тогтмол, өдөр бүр тухайн үйлийн зорилготой уялдаатай тодорхой давтамжтайгаар гүйцэтгэж буй үйлийн 40-60 хувийг зарцуулж байгаа бол 1,4-р зорилтын хүрээнд хийх зарим ажлыг, тухайлбал, 1-р бүлэг ажлын сургалтад суух, 4-р бүлэг ажлын эцэг эх, асран хамгаалагчтай холбогдох ажлыг 7 хоногт 1-3 удаагийн давтамжтайгаар өдөрт гүйцэтгэж буй үйлийн 5-10 хувийг зарцуулж байгааг ажиглалтын судалгаа харуулж байна.

Судалгааны үр дүнг дүгнэвэл дараах байдалтай байна:

- Судалгааны чанарын аргаар багшийн ажлын байрны зураглалыг хийж цэцэрлэгийн багшийн өдөр тутам хийж буй ажлыг илрүүлэн тухайн үйл ажиллагаанд хэр хугацааг зарцуулж байгааг тандан гаргаснаараа онцлогтой.
- Цэцэрлэгийн багш өдрийн дэглэмийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд хүүхэд хамгаалал, эрүүл мэндийг дэмжих, ангид аюулгүй орчныг бүрдүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад ихэнх цагийг зарцуулж байв.
- Багш хүүхдүүдийг тоглуулах, чөлөөт үйл ажиллагааг хийх боломжийг бага бүрдүүлж цагийн хуваарийн дагуу үйл ажиллагаанд чиглүүлэхэд илүү анхаарч байгааг ажиглалтын судалгаа харууллаа.
- Бүлгийн багш нар эцэг эх, асран хамгаалагчидтай хүүхэд хүлээн авах, тарах үед богино хугацаанд харилцан ярилцах, эрүүл мэндтэй холбоотой эсвэл тодорхой зүйл лавлах асуудлаар утсаар холбогдож байгаа нь ажиглагдлаа.
- Түршилтын цэцэрлэгийн бүлгийн багш нар сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, сургалтын хэрэглэгдэхүүн хийх, ээлжийн агшид зөвлөгөө өгөх ажлыг өдөр бүр зохион байгуулж байв.
- Ээлжийн багш нар хөгжөөн баясах үйл ажиллагааг өдөр бүр, олон аргаар, бие даан зохион байгуулж байгаа нь ажиглагдлаа.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Цэцэрлэгийн багшийн ажиллаж буй цагийг 2006, 2019 оны судалгааны үр дүнтэй харьцуулан авч үзэхэд бидний судалгааны үр дүнтэй адил байгаа ба өдөр бүр 10-12 цаг ажиллаж байна. Бидний түршилтын явцад цэцэрлэгийн 4-5 цагийн үйл ажиллагааг оюутан ээлжийн багш зохион байгуулж тэр хугацаанд бүлгийн багш сургалт, үйл ажиллагаанд бэлтгэх, өөрийгөө хөгжүүлэх, өөртөө цаг зарцуулах боломжтойг судалгаа харуулж байна. Мөн цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулснаар бүлгийн багшийн ажлын цагийг хөдөлмөрийн хуулийн дагуу явуулах, оюутан мэргэжилдээ дадлагажих боломж бүрдэж, цаашид ажиллуулах бүрэн боломжтойг түршилтын явцад илрүүлж харууллаа. Иймд цэцэрлэгт ээлжийн багшаар төгсөх ангийн оюутан ажиллах нь үр дүнтэй байна.

ДҮГНЭЛТ

- Ээлжийн багш ажиллуулах түр журам боловсруулан гаргасан нь түршилтыг хэрэгжүүлж буй цэцэрлэгүүдэд эрх зүйн орчин бүрдэж, дэмжлэг болсон учраас энэхүү үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.
- Ээлжийн багш ажиллуулснаар бүлгийн багшийн ажиллах цаг буурч, сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх цаг гарч байгаа нь бүлгийн багшийн мэргэжлийн хөгжилд дэмжлэг болоод зогсохгүй хүүхдийн хөгжлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулах юм.
- Бүлгийн багш нар өөртөө болон гэр бүлдээ цаг гаргах боломж бүрдэж байгаад сайшаалтай байгаа хэдий ч илүү цагийн хөлс хасагдсанд таагүй байгааг ярилцлагын судалгаа харуулж байна. Иймд тэднийг ажлын цагтаа тарж ээлжийн багш ажиллах цагт үр дүнтэй өнгөрүүлэхэд бэлтгэх, чиглүүлэх шаардлагатай байгааг анхаарч бүлгийн багш нарт чиглэсэн энэхүү нөхцөлд дасан зохицох боломж бүрдүүлэх нь чухал байна.

- Ээлжийн багш нарт цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчид, бүлгийн багш нар сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж байгаа нь оюутан ажилдаа дадлагажихад хувь нэмэр оруулж байна.
- Оюутан ажилдаа дуртай, хүүхэдтэй ажиллахдаа сонирхолтой, ажлаа хийх хүсэл эрмэлзэлтэй болж байгааг харгалзан үзэж оюутан ээлжийн багшаар ажилллуулах үр дүнтэй болохыг судалгаа харууллаа.
- Ээлжийн багшийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхдээ оюутны хичээлийн цагийн зохицуулалтыг хийсэн нь тохиромжтой байсан хэдий ч тэднийг хичээлээ бүрэн судлах, ажил хичээлийн ачааллыг тооцож урьдчилан шийдвэрлэх, тухайлбал, хичээлд бүрэн суух, ажиллах хүсэл сонирхолтой, хариуцлагатай байх тал дээр анхаарч түүнд чиглэсэн зохицуулалтыг оновчтой хийх хэрэгтэйг туршилтын үйл ажиллагаа харуулж байна.
- Ээлжийн багш ажиллах хэрэгтэй ба ажиллуулах боломжтой гэж туршилтын үйл ажиллагааг зохион байгуулсан цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, бүлгийн болон ээлжийн багш нар хариулсан нь цаашид ээлжийн багш ажиллуулах нөхцөл бүрдсэнийг харуулж байна.
- Эцэг эх, асран хамгаалагчид өглөө эрт цэцэрлэг нээж байгаа учраас ажилдаа цагтаа явах боломжийг бүрдүүлсэн бөгөөд эрт өгч байгаа тул түр журамд заасны дагуу хүүхдээ 10 цаг болгоод авч байгаа байдал ажиглагдлаа. Энэ нь эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэй хамтдаа байх цагийг нэмэгдүүлсэн чухал шийдэл байж болох талтай.
- Багш өдрийн дэглэмийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд албан тушаалын чиг үүргийн хүрээнд мэргэжлийн хөгжлийг дэмжих арга зүйн сургалтад суух, бага насны хүүхдийн аюул осолгүй байдлыг хангах, хамгаалах, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх, хүүхдийн хөгжлийг үнэлэх, сургалтын орчныг бүрдүүлэх ажлыг тодорхой хэмжээнд, давтамжтайгаар гүйцэтгэж байна.
- Эцэг эх, асран хамгаалагчидтай утсаар болон хүүхдээ өгч, авах цаг хугацаанд харилцан ярилцах, асуулт асуух, сануулах байдлаар ажиллаж байгаа нь ажлын 5 өдөрт туршилтын цэцэрлэгийн 7 багш, хяналтын цэцэрлэгийн 11 багш тодорхой хэмжээнд давтамжтайгаар хийж байгаа нь ажиглагдсан. Ажиглалтын судалгаанд хамрагдсан багш нарын 75 хувь нь л зөвхөн асуулт асуух байдлаар эцэг эх, асран хамгаалагчтай ажиллаж байгаа нь анхаарал татаж байна. Эцэг эх, асран хамгаалагчтай зорилготой ярилцлагаар биш энгийн асуулт, хариултын хүрээнд явж байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

НОМ ЗҮЙ

legalinfo.mn. (2021). Хөдөлмөрийн тухай хууль. Улаанбаатар.

БСШУЯ, Боловсролын хүрээлэн. (2006). *Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ажлын ачаалал, үнэлгээ*. Улаанбаатар.

БШУЯ. (2022). *2021-2022 оны статистик мэдээлэл*.

Дэлхийн банк, БТДНТ. (2019). *Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын тайлан*. Улаанбаатар.

Дэлхийн банк, БТДНТ. (2019). *Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын тайлан*. Улаанбаатар.

Монгол Улсын Засгийн газар. (2019). *Алсын хараа 2050*. Монгол улсын үрт хугацааны төлөвлөгөө.

Монгол Улсын Засгийн газар. (2020). *БШУЯ*. Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөө.

МУ-ын Их Хурлын Тогтоол. (2020 оны 8 28). *МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай*.

ТАЛАРХАЛ

Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах туршилтын үйл ажиллагааг санаачилсан БШУЯ-ны СӨБ-ын хэлтэс, судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлсэн БСҮХ (тухайн үеийн Боловсролын хүрээлэн)-ийн удирдлага болон судлаачдадаа, хамтран ажилласан БЕГ (тухайн үеийн БМДИ), НБГ, МУБИС-ийн СӨБС -д талархал илэрхийлье.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс, санаа: Д.С., Г.М; Арга зүй: Д.С., Г.М., Х.О; Мэдээлэл цуглуулалт: Д.С., 16 ЭША; Бичилт (эхний хувилбар): Д.С., Х.О; Бичилт (засвар): Д.С., Х.О; Нөөц: Д.С; Мэргэжлийн удирдлага: Х.О.

A pilot study on employing student shift teachers to balance pre-school teachers' working hours

Abstract

Authors

Sarantuya, D¹, Mongolkhatan, G², Otgonbaatar, H³
^{1,2,3} Curriculum, Assessment and Textbook,
Mongolian National Institute for Educational
Research (MNIER)

Keywords:

group teacher; shift teacher; job duties; pilot activity; teacher working hour

Education policy documents in Mongolia explicitly state to improve the quality of kindergarten teachers' work and to support kindergarten teachers with an environment that enables them to have sufficient time for teaching and learning activities and self-development, to observe kids, and to carry out research. Moreover, it is clearly stated to have two shift teachers for each group at kindergarten starting in 2023. This study examines the implementation of a shift teacher pilot policy at kindergartens, which aims to maximize time to support child development and balance the workload of pre-school teachers. We employed mixed methods to collect data regarding shift teacher activities during the pilot period. This article reports key findings of the shift teacher pilot policy. In particular, kindergarten teachers' working hours were reduced, and positive outcomes were observed in shift teachers' pedagogy and strategy to work with kids and collaboration among kindergarten teachers, specialists, and kids.

Recommended Citation

Dorj, S., Gunsen, M., Khajidmaa, O. (2022). A pilot study of employing student shift teachers to balance pre-school teachers' working hours. *Mongolian Journal of Educational Research*, 27(1). 29-43. DOI: <https://doi.org/10.56380.v27.3>